



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn](https://www.facebook.com/Rtcc.mn)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2018 оны 9-р сарын дугаар



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын хоногийн болон сарын статистик мэдээг салбарын мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлтийн мэдээ
- Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ /өссөн дүнгээр/
- Ачилтын мэдээ /ачааны төрлөөр, өссөн дүнгээр/
- Дамжин өнгөрөх ачааны мэдээ /чиглэл, зуучлагч, төрлөөр, өссөн дүнгээр/
- Чингэлэг тээвэрлэлтийн мэдээ /чиглэл, зуучлагчаар, өссөн дүнгээр/
- Зорчигч тээвэрлэлтийн мэдээ
- Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын мэдээнүүд багтаж байна.

Статистик мэдээллийг нэгтгэх, боловсруулах, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангаж холбогдох байгууллагуудаас хоногийн болон сарын мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд авч бүрдүүлсэн үнэн зөв мэдээ, мэдээллээр тогтмол хангаж ажиллалаа.



“Modern Railways”, “Railway Magazine Trains”, “Railway Digest” сэтгүүлүүдийн дугаарыг төвийн сайтад байршууллаа

Төвийн цахим хуудаст гадаад улсын “Modern Railways, Railway Digest, The Railway Magazine Trains” сэтгүүлийн 9-р сарын дугааруудыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн харах хэлбэрээр www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээллээ.

SIEMENS WINS £1.5BILLION PICCADILLY LINE ORDER

The **RAILWAY** *Magazine*

BRITAIN'S BEST-SELLING RAIL TITLE
July 2010

West Coast Railways' Lake District lifeline

£5bn rail investment for Wales

Now trains, new identity, electrification and more

GBRf buys 16 Class 56s

CLASS 66 - FREIGHT WITHOUT FRONTIERS FRANCO-CROSTI LO-COMOTIVES ALTERNATIVE FUELS FOR TRAINS

WORLD'S THIRD OLDEST LOCOMOTIVE DISCOVERED ON TYNESIDE

ON YOUR FREE DVD
PENDON PT. 2, A TRIP TO TMC, INSIDE HATTONS

BRITISH RAILWAY MODELLING

BRM VINTAGE

STOP PRESS • STOP PRESS • STOP PRESS
MAIL-ON NEWS FROM HORNBY AND BRACHMAN

ALSO THIS ISSUE

- GLASS, BEFORE IT WAS STATIC
- TRI-ANG RETROSPECTIVE
- BORCHESTER TRACKPLAN SPECIAL
- AND MORE...

CLASSIC LAYOUTS & TRUSTED TECHNIQUES IN 00, 0, EM AND 2FS

VINTAGE

MINERVA FROM IRINN, DIGITAL SOUND CONTROLLER 5, DCC SIGNALS, TMIC, BOLSTER WAGONS

EXCLUSIVE


BRM MEETS DAVE ROWE

REVIEWED

Зорчигч тээвэрлэлт 2018 оны наймдугаар сард 255.2 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 %-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 2018 оны наймдугаар сард 2136.5 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4 %-иар өссөн үзүүлэлттэй байна.




ИНФОГРАФИК



Нийт тасалдлын 134-н тасалдад буюу 59.56 %-ийг техникийн савалт (зүтгүүр эзэрсэн, дохио автомашин хаягдан зарж). 29-н тасалдад буюу 12.89%-ийг техникогийн зөрчин, 62-н тасалдад буюу 27.56 %-ийг бусад шалтгаан залыг байна. Технологийн зөрчлийн чухтан тасалдлын хэмжээ оноос сардас 4н нийзжээр буурсан хөхирлын хэмжээ 2 001 784 т-өөр буурсан, техникийн саваллас чухтан тасалдлын хэмжээ 5н нийзжээр өсөж хөхирлын хэмжээ 97 742 т-өөр буурсан. Бусад шалтгааныас чухтан тасалдлын хэмжээ 2 нийзжээр буурсан хөхирлын хэмжээ мөн 25 930 117 т-өөр өссөн үзүүлэлттүүдэй байна.




Зорчигчийн галт тэрэгний явуулалтваар 644 г/т төлөвлөснөөс 624 г/т явуулж билэлт 96.89 %, энгэрүүлэлтээр 598 г/т төлөвлөснөөс 573 г/т энгэрүүлж билэлт 95.82 %, ачааны галт тэрэгний явуулалтаар 4386 г/т төлөвлөснөөс 4349 галт тэрэг явуулж билэлт 99.16 %, энгэрүүлэлтээр 3452 г/т төлөвлөснөөс 3309 г/т энгэрүүлж 95.86 % болж ерхжийн дун зурмагийн билэлт 96.93 % болж байна.




СТАТИСТИК

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт




Зорчигч тээвэрлэлт 2018 оны наймдугаар сард 255.2 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 2018 оны наймдугаар сард 2136.5 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Ачилт- ачааны төрлөөр /2018-I-VIII/



Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/




Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны эхний 8 сард 2257256.9 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үеэс 267985.8 тн буюу 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны эхний найман сард ачилт 11868.40 мян.тн өмнөх оны мөн уятдай харьцуулбал 13.6 %-иар өссөн. Эдгэрээс нүүрс, темрийн худэр, мод, модон материал, зэс молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 3 дугаар улиралд: Зорчигч тээвэрлэлт 2018 оны 3 дугаар улиралд 1961.4 мян.хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -1.8%-иар буурсан, ачаа тээвэрлэлт нь 2018 оны 3 дугаар улиралд 18721.0 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 15.2%-иар өссөн үзүүлэлттэй байна.




ИНФОГРАФИК




СТАТИСТИК

Төмөр замын тээврийн үндсэн




Зорчигч тээвэрлэлт 2018 оны есдүгээр сард 194.9 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн уетж адил, ачаа тээвэрлэлт 2018 оны есдүгээр сард 2243.8 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн уеэс 11%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Ачилт- ачааны төрлөөр /2018-IX/



Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/



Дамжин өнгөрсөн ачаа 2018 оны есдүгээр сард 277148.1 тн ачсан нь өнгөрсөн оны мөн уеэс 46754.4 тн буюу 20.3 хувиар өссөн байна.

2018 оны есөн сард ачилт 2161.0 мян.тн ачсан нь өмнөх оны мөн уетж харьцуулбал 35.7%-иар өссөн ба есдүгээр сард мод, модон материал, тоног төхөөрөмж, хүнсний ачаа, хар төмөр өссөн үзүүлэлттэй байна.

Мод, модон материал	62%
Химийн ачаа	20%
Бусад ачаа	6%
Тоног төхөөрөмж	5%
Чулуун нүүрс	3%
Хүнсний ачаа	2%
Барилгийн ачаа	2%

Мэдээ, мэдээлэл



Суурь бүтцийн 2018 оны 9-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын тайлан

2018 оны 9-р сард нийт 172 тасалдал, 217,9 галт тэрэг цагийн барилт үүсч, 33,42 сая төгрөгийн хохирол гарсан байна.

Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:



Тасалдлаас үүссэн хохирол, сая төгр



Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 53 нэгж буюу 23,5%-иар, галт тэрэг цаг 142,1 н цаг буюу 39,4%-иар, хохирлын хэмжээ 37,83 сая төгрөг буюу 53,1%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:





2018 оны 1 ба 3-р саруудад “ММЗИХ” ТББ-аас зохион байгуулсан салбарын мэргэшлийн зэрэг олгох сургалтад хамрагдсан инженерүүдээс шалгалт авч шалгалтын дүнг орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн 2018 оны 9 сарын 7-ны өдрийн 286-р тушаалаар баталгаажуулан гэрчилгээжүүллээ.

Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох нийтлэг дүрмийг шинэчлэх төслийг боловсрууллаа.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж, үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн наймдугаар сарын тээвэрлэлтийн мэдээг албан бичгээр ЗТХЯ-нд хүлээлгэн өглөө.

БНХАУ-ын HollySys Tech Co.,Ltd технологийн компанийн санал болгосон Монгол орны төмөр замын өнөөгийн байдалд тохиорохуйц техник технологи, бүтээгдэхүүний үнэ ханш, PTC / Positive Train Control/ системийн бүтэц үйл ажиллагаа, механизмыг судалж байна. Мөн тус системээс харьцангуй хялбар технологи санал болгож буй АНУ-д төвтэй CTI Electronics Ltd компанийн технологийн судалгааг хийж байна.

“МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ний төмөр замын мэдээллийн сүлжээг төвийн дотоод сүлжээний файл шэйринг програм хангамжид нэгтгэхээр мэдээлэл байршуулах талбарыг үүсгэж програмд нэвтрэн орж мэдээлэл байршуулах мэргэжилтэнд зааварчилгаа өглөө.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд ЗТХЯ болон MCX-той хамтран ажиллалаа.

“МИСТ”ХХК-ны хүсэлтийн дагуу 20 футийн дээвэргүй /опен топ/ чингэлгээр экспорт, импортын ачааг тээвэрт оруулах, шинээр чингэлэг бүртгэх, хөтлөх маягт №1 бөглөх зааврын хамт боловсруулан “МИСТ”ХХК-ны 100 чингэлгийг маягтаар бүртгэн авч мэдээллийн санг баяжуулсан.

Төвийн 2014-2018 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, 2019-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллаж байна.

Мэдээ, мэдээлэл



Зам тээврийн хөгжлийн сайдын 146 дугаар тушаалаар үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг зохион байгуулах чиг үүрэг бүхий салбар комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан салбарын ажлын хэсгээс гаргасан төлөвлөгөөний дагуу нийт 147 стандартын баримт бичигт үзлэг хийн санал боловсруулж ЗТХЯ-д хүргүүллээ.



2018.09.12-ны өдрүүдэд “УБТЗ“ХНН”-ийн Баянтумэн тасагт томилолтоор ажиллаж тасгийн үйл ажиллагаа болон зурмагийн биелэлт, салбар замуутдтай танилцсан.



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит:

Захирлын хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд батлан гаргасан үйл ажиллагааны холбогдолтой тушаалын хэрэгжилтэд III улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж тушаалын бислэлт 81,3 хувьтай байна.

Төвийн захирлын 2018.09.11-ний өдрийн “Ажил эрчимжүүлэх тухай” А/59 дүгээр тушаалын 1.4, 1.5 дахь заалтыг хэрэгжүүлж үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийллээ. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд нийт 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100%-ийн биелэлттэй 31, 90%-ийн биелэлттэй 1, 70%-ийн хэрэгжилттэй 2, 50%-ийн хэрэгжилттэй 5, 30%-ийн хэрэгжилттэй 8 арга хэмжээтэй, хэрэгжилт 81,3%-тай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг III улирлын байдлаар гаргаж, яамны ХШУДАГ-ын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд 2018.09.14, 2018.09.19-нд цахим хэлбэрээр, 2018.09.20-ны 265 дугаартай албан бичгээр тус тус хүргэж тайлагналаа.



Хүний нөөц:

Ажлын байрны 2 сул орон тоо гарсантай холбогдуулан “Ган зам” сонинд сонгон шалгаруулалтын зарыг байршуулж олон нийтэд мэдээлсэн.

ЗТХЯ-наас төвийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд өгсөн санал зөвлөмжийн хүрээнд <http://rtcc.mrtd.gov.mn/> “Ил тод” буланд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, ажилтны ёс зүйн дүрэм, ажилтны албан тушаал, утасны жагсаалт, хөдөлмөрийн дотоод журмын нэмэлт өөрчлөлт зэрэг мэдээллийг байрлуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн мэдээллийг 2018 оны III улирлын байдлаар гаргаж ЗТХЯ-ны ТЗҮГ-т хүргүүлсэн.

Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах, ажилтны ажлын үр дүн, урамшуулалтыг хариуцлагатай холбох зэрэг зохицуулалтыг тусгасан хөдөлмөрийн дотоод журмын нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулж, удирдлагад танилцуулсан.



Санхүү бүртгэл:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг rtcc.mrtd.gov.mn, info.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж мэдээлж байна.

Шилэн дансны хүрээнд тухай бүр оруулах 8 төрлийн мэдээг 72 удаа, сар бүр оруулах 3 мэдээг 27 удаа, бүтэн жилээр оруулах 4 мэдээг 1 удаа бэлтгэн хугацаанд нь тайлагнасан.

Төсвийн тухай хуулийн хүрээнд 2019 оны төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийг боловсруулж 28 хуудас судалгаа, тооцоо бүхий баримтыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.

Шилэн данс болон худалдан авах ажиллагаатай холбоотой тайлангуудыг бэлтгэн Сангийн яамны shilendans.gov.mn цахимд тайлагнаж, ЗТХЯ-ны ХШҮДОГ-т албан бичгээр хүргүүлсэн.



Дотоод үйл ажиллагаа:

Захирлын шуурхай зөвлөгөөн 2018.09.03, 2018.09.10, 2018.09.17-нд 3 удаа хуралдсан. Шуурхай зөвлөгөөнөөр цаг үеийн асуудлаар болон төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлыг эрчимжүүлэх, сахилга хариуцлагыг чангатгах, дотоод үйл ажиллагаатай холбоотой 45 Үүрэг даалгавар өгөгдсөн.

Мэдээ, мэдээлэл



“ГТХЗНТ” УТҮГ-ын салбарын судалгааны мэргэжилтэн

Г.Чангас 2018 оны 8 дугаар сарын 29-өөс 9 дүгээр сарын 20-ны хооронд БНХАУ-ын Ченду хотод болсон Хятадын Худалдааны зохион байгуулсан “ НЭГ БҮС НЭГ ЗАМ” төсөлд оролцогч орнуудын мэргэжилтнүүдийг хамруулсан “Төмөр Замын төлөвлөлт ба бүтээн байгуулалтын менежмент” семинаарт “Seminar on Railway Planning and Construction Management” оролцлоо.



Мэдээллийн цаг, сургалт арга хэмжээ:

“Өвөлжилтөд хэрхэн бэлтгэх”, “Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулга”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах нь” сэдвээр сургалтуудад төвийн мэргэжилтнүүд хамрагдлаа.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Дахин үнэлгээ хийхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах, төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн цахимд хөрөнгийн бүртгэлийг хэрхэн бүртгүүлэх тухай” сургалтанд төвийн нягтлан бодогч хамрагдсан.



 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
З-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

